



МОНГОЛБАНК
МОНГОЛ УЛСЫН ТӨВ БАНК

ИРГЭДИЙН САНХҮҮГИЙН МЭДЛЭГИЙН ТҮВШИН ТОГТООХ СУДАЛГАА

Гүйцэтгэгч:
САНХҮҮГИЙН ХҮРТЭЭМЖ-ХӨГЖИЛ САНААЧИЛГА



УЛААНБААТАР
2022

АГУУЛГА

ТАНИЛЦУУЛГА	4
Удиртгал.....	4
Судалгааны аргачлал.....	5
САНАЛ АСУУЛГАД ОРОЛЦОГЧДЫГ ТОДОРХОЙЛОХ СТАТИСТИК	6
Нас, хүйс, байршил.....	6
Ажил эрхлэлт.....	6
Орлого, зарлагын байдал.....	7
Зээлжилт болон санхүүгийн төлөв байдал.....	9
САНХҮҮГИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ТАЛААРХ ОЙЛГОЛТ, ХЭРЭГЛЭЭ	11
САНХҮҮГИЙН БОЛОВСРОЛЫН ЧАДАМЖ	13
САНХҮҮГИЙН МЭДЛЭГ.....	14
ЭДИЙН ЗАСГИЙН МЭДЛЭГ.....	16
САНХҮҮГИЙН ХАНДЛАГА.....	18
ДҮГНЭЛТ	24

ХҮСНЭГТ

Хүснэгт 1. Судалгааны ерөнхий загвар.....	5
Хүснэгт 2: Санхүүгийн бүтээгдэхүүний талаарх мэдлэг, хэрэглээ	11
Хүснэгт 3. Санхүүгийн бүтээгдэхүүний хэрэглээ, насны бүлгээр.....	11
Хүснэгт 4: Санхүүгийн мэдлэгийн асуултуудад зөв хариулсан байдал	15
Хүснэгт 5: Эдийн засгийн мэдлэгийн зөв хариулт.....	16

ЗУРАГ

Зураг 1. Судалгаанд оролцогчийн байршил, хүйс	6
Зураг 2. Ажил эрхлэлтийн байдал	6
Зураг 3. Орлогын гол эх үүсвэр.....	7
Зураг 4. Орлогын хэмжээ	7
Зураг 5. Орлогын зарцуулалт	8
Зураг 6. Гэнэтийн зардал гарахад хэрхэн шийдэх вэ?	8
Зураг 7. Зээлжилт.....	9
Зураг 8. Өөрийн ирээдүйн санхүүгийн төлөв байдлын талаарх төсөөлөл	9
Зураг 9. Санхүүгийн боловсролын чадамж, улсын дундаж	13
Зураг 10. Санхүүгийн боловсролын чадамж, улсын дундаж	13
Зураг 11. Санхүүгийн мэдлэгийн улсын дундаж үзүүлэлт.....	15
Зураг 12. Санхүүгийн мэдлэг, насны ангиллаар	16
Зураг 13. Эдийн засгийн мэдлэгийн улсын дундаж үзүүлэлт	17
Зураг 14. Эдийн засгийн мэдлэг, насны ангиллаар	17
Зураг 15. Санхүүгийн төлөвлөдөг эсэх	18
Зураг 16. Хуримтлал үүсгэх хандлага.....	19
Зураг 17. Санхүүгийн хандлагын улсын дундаж үзүүлэлт	19
Зураг 18. Санхүүгийн хандлага, насны ангиллаар	20
Зураг 19. Санхүүгийн шийдвэр гаргахдаа зөвлөгөө авдаг эсэх	20
Зураг 20. Хэнээс санхүүгийн зөвлөгөө авдаг вэ?	21
Зураг 21. Санхүүгийн луйвар, залилангаас сэргийлэх хандлага.....	21
Зураг 22. Сүлжээний бизнес, санхүүгийн луйврыг танихдаа хаанаас мэдээлэл авдаг вэ? ..	22
Зураг 23. Монголбанктэй холбоотой мэдээллийн эх сурвалж	22
Зураг 24. Санхүүгийн боловсрол олгох сургалтыг аль хэлбэрээр авахыг илүүд үзэх вэ?... 23	

ХАВСРАЛТ

Хавсралт 1. Судалгаанд оролцогчдын байршил, насны бүлгээр	26
Хавсралт 2. Судалгаанд оролцогчдын ажил эрхлэлтийн байдал, насны бүлгээр	26
Хавсралт 3. Судалгаанд оролцогчдын орлогын эх үүсвэр, насны бүлгээр	27
Хавсралт 4. Судалгаанд оролцогчдын тухай, насны бүлгээр.....	27
Хавсралт 5. Санхүүгийн төлөвлөлт, насны бүлгээр.....	28
Хавсралт 6. Зээлийн тухайд, насны бүлгээр	28
Хавсралт 7. Хадгаламж, эрсдэл даах чадвар, насны бүлгээр	28
Хавсралт 8. Судалгаанд оролцогчдын тухай нэмэлт мэдээллүүд, насны бүлгээр.....	29
Хавсралт 9. Санхүүгийн боловсролын чадамж, насны бүлгээр	30
Хавсралт 10. Санхүүгийн боловсролын чадамж, хүйс ба байршлаар.....	30

Хавсралт 11. Санхүүгийн боловсролын чадамж, насны бүлэг ба байршлаар	31
Хавсралт 12. Санхүүгийн боловсролын чадамж, ажил эрхлэлтийн байдлаар	31
Хавсралт 13. Санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээний хэрэглээ, ажил эрхлэлтийн байдлаар	32
Хавсралт 14. Санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээний хэрэглээ, байршлаар	33

ТАНИЛЦУУЛГА

Удиртгал

Санхүүгийн тогтвортой байдлыг хангах, санхүүгийн зах зээлийн хүртээмжийг нэмэгдүүлэхэд иргэд, олон нийтийн санхүүгийн мэдлэг, оролцоо нэн чухал үүрэгтэй. 2012 онд Монгол улсын иргэдийн санхүүгийн мэдлэгийн түвшинг тогтооходтой холбоотой хэд хэдэн судалгааны ажил хийгдсэн байдаг бөгөөд тэдгээрээс зарим үр дүнг онцолж үзвэл иргэдийн санхүү, эдийн засгийн суурь мэдлэг ихээхэн хангалтгүй байв. Тухайлбал,

1. “Санхүүгийн мэдлэг Монголд” суурь судалгаа:

- 10 хүний 6 нь инфляц хадгаламжид хэрхэн нөлөөлөх талаар ойлголтгүй
- Судалгаанд оролцогчдын 70% нь зөвхөн гурван төрлийн санхүүгийн үйлчилгээ үзүүлдэг байгууллагын төрлийг мэддэг.
- Хүн амын 57% нь ирээдүйгээс илүү одоо байгаа нөхцөл байдалдаа анхаарлаа хандуулдаг.
- 30 орчим хувь нь хүүгийн талаар ойлголтгүй гэх үр дүн гарч байжээ.

2. Дэлхийн банкны “Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах, санхүүгийн суурь боловсролын өнөөгийн байдлын оношилгоо дүгнэлт” тайлан:

- Монголын насанд хүрсэн хүн амын 78% нь албан ёсны санхүүгийн байгууллагад данс эзэмшдэг ба энэ нь Зүүн Ази, Номхон далайн бусад орнуудын дунджаас харьцангуй өндөр үзүүлэлт байж.
- 61 хувь нь дебит карт ашигладаг.
- Энэхүү тайланд иргэдийн санхүүгийн мэдлэг, суурь боловсролыг сайжруулах зохицуулалтыг бий болгох шаардлагатайг дурдсан байдаг.

Дээрх судалгаануудын үр дүнгээс харахад манай улсын иргэдийн санхүүгийн мэдлэг хангалтгүй байгаа бөгөөд санхүүгийн тогтвортой байдлыг хангахын тулд олон нийтийн санхүүгийн мэдлэг, боловсролыг дээшлүүлэх хэрэгцээ, шаардлага байна гэсэн дүгнэлтэд хүрч Монголбанкнаас санаачлан “Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөр 2015-2021” дунд хугацааны хөтөлбөр хэрэгжүүлж эхэлсэн.

Хөтөлбөрийн алсын хараа: Монгол улсын иргэд өөрийн болон өрхийн санхүүгээ зохистой удирдах мэдлэг, чадвар болон итгэл үнэмшилтэй болно.

Хөтөлбөрийн зорилго:

- Иргэдийн хувийн санхүүгээ зохистой удирдах чадварыг дээшлүүлэх
- Иргэдийг санхүүгийн залилангаас өөрийгөө хамгаалах чадвартай болгох
- Санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх ажлын байгаа нөөц бололцоог зөв, үр ашигтай зарцуулан явуулах
- Санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэхэд оролцож байгаа байгууллага болох хувь хүмүүс үр дүнтэй хамтран ажиллах, мэдээлэл солилцох нөхцөлийг бүрдүүлэх

Хөтөлбөрт тодорхойлсноор, санхүүгийн чадавх, суурь мэдлэг гэдэг нь иргэн өөрийн нөхцөл байдалд тохируулан санхүүгийн зохистой шийдвэр гаргах, арга хэмжээ авч хэрэгжүүлэхэд шаардагдах мэдлэг, чадвар, хандлагыг хэлнэ.

Дээрх хөтөлбөрийн дараах иргэдийн санхүүгийн болон эдийн засгийн суурь мэдлэгийн түвшинг хэмжиж, уг хөтөлбөр зорилтот бүлэгт хүрч өөрчлөлт гарсан эсэхэд үнэлэлт өгөхөд шаардлагатай өгөгдөл цуглуулах зорилгоор энэхүү судалгааны ажлыг Монголбанкны захиалгаар “Санхүүгийн Хүртээмж-Хөгжил Санаачилга” ТББ 2022 оны 6-9 дугаар сард гүйцэтгэв.

Судалгааны аргачлал

Судалгаанд түүвэрийг эх олонлог буюу монгол улсын 15-69 насны 2'228'639 иргэдийг 95 хувийн итгэх түвшинд, 2.52-ийн алдааны алдааны интервалтайгаар төлөөлөх чадвартай байхаар Улаанбаатар хот болон хөдөө орон нутгийн нийт 14 аймгийн 15-69 насны 1506 хүнийг аймаг, нийслэл тус бүрийн хүн амын тоонд харьцуулж, санамсаргүй түүврийн аргаар сонгож, нүүр тулсан ярилцлага хийсэн. Орон нутгийн түүврийг аймгийн төв ба сум гэж ангилан бүхэлдээ төлөөлөх чадвартай байхаар төлөвлөж нийт 806 оролцогчийг аймаг тус бүрийн хүн амын тооны харьцаагаар хуваарилсан.

Судалгааг гүйцэтгэхдээ Эдийн засгийн хөгжил, хамтын ажиллагааны байгууллага /OECD/-ын Санхүүгийн боловсролын олон улсын сүлжээ /INFE/ байгууллагаас 2018 онд боловсруулсан Санхүүгийн мэдлэг болон хүртээмжийг хэмжих судалгааны загварыг¹ суурь болгон ашиглаж, нэмэлт асуултуудаар баяжуулсан болно. OECD/INFE-ээс “Санхүүгийн боловсролын чадамж нь санхүүгийн шийдвэр гаргаж, хувийн санхүүгээ сайжруулахад шаардлагатай санхүүгийн мэдлэг, чадвар, зан төлөв ба хандлага зэргийн цогц нийлбэр юм” гэж авч үздэг.

Харин энэ удаагийн судалгаанд захиалагчтай зөвлөлдсөний дагуу санхүүгийн зан байдлын бүрдэл хэсгийг хасч эдийн засгийн ерөнхий мэдлэгийн асуултуудыг нэмж оруулан тэдгээрийн нийлбэр дүнгээр санхүүгийн боловсролын чадамжийг тодорхойлов. Учир нь уг судалгаа нь иргэдийн санхүүгийн болон түүнтэй уялдаатай эдийн засаг, салбарын мэдлэгийг үнэлэх үндсэн зорилготой байсан.

Хүснэгт 1. Судалгааны ерөнхий загвар

САНХҮҮГИЙН БОЛОВСРОЛЫН ЧАДАМЖ²

Financial Literacy Competence

САНХҮҮГИЙН МЭДЛЭГ Financial Knowledge	САНХҮҮГИЙН ХАНДЛАГА Financial Attitude	ЭДИЙН ЗАСГИЙН СУУРЬ МЭДЛЭГ Economic Literacy
--	---	---

Эдгээр хүчин зүйлст нөлөөлөх профайлын үзүүлэлтүүд:

Хүн ам зүй, оршин суугаа газрын онцлог	Санхүүгийн төлөв байдлын үзүүлэлтүүд
--	--------------------------------------

Уг судалгаа нь иргэдийн санхүүгийн боловсролын чадамжийг 3 түвшинд хэмжиж, тодорхойлох зорилготой тул нүүр тулсан санал асуулгын аргаар cross-sectional тоон мэдээлэл цуглуулав. Нэмэлтээр эдийн засаг, санхүүгийн системийн талаарх зарим суурь ойлголтын талаарх мэдлэгийн ерөнхий байдлыг тандаж ярилцлага хийсэн.

Асуулга нь санхүүгийн мэдлэг, хандлагыг илэрхийлэх 20 үзүүлэлтийг тодорхойлох үндсэн 35 асуулт болон эдийн засаг, санхүүгийн системийн талаарх суурь ойлголтыг тандах 6, профайлын 9, нийт 50 асуултаас бүрдэнэ. Асуултууд нь оноогоор үнэлэх, давтамж болон санал нийлэх байдал, тоон интервал сонгох, зөв буруу, тийм үгүй зэрэг хэлбэрүүдээр бүтэцлэгдсэн.

¹ [OECD/INFE toolkit for measuring financial literacy and financial inclusion](#)


² Тайланд Санхүүгийн боловсролын цогц чадамж гэх тодорхойлолтыг энэ судалгааны загвараар тодорхойлсон хязгаарлагдмал хүрээнд ойлгож ашиглана.

САНАЛ АСУУЛГАД ОРОЛЦОГЧДЫГ ТОДОРХОЙЛОХ СТАТИСТИК

Нас, хүйс, байршил

Түүвэр судалгаанд нийт 1947 хүн хамрагдсанаас 36.0% нь Улаанбаатар хотоос, үлдсэн 64.0% нь орон нутгийн Зүүн, Баруун, Төв, Хангайн бүсийн нийт 20 аймгийн иргэд байна. Насны бүтцийн хувьд 18-24 насны иргэд 16.4%, 25-39 насны иргэд 39.5%, 40 болон түүнээс дээш насны иргэд 44.1%-ийг тус тус бүрдүүлж байна. Үүнээс хүйсээр нь ялган харвал, 58.7% нь эмэгтэй, 41.3% нь эрэгтэй хүмүүс байна.


Зураг 1. Судалгаанд оролцогчийн байршил, хүйс



Ажил эрхлэлт

Нийт судалгаанд оролцогсдын 69.2% нь тогтсон ажилтай буюу хувиараа бизнес эрхэлдэг, эсвэл хувийн хэвшил, болон улсын байгууллагуудад ажилладаг. Эдгээр тогтмол ажилтай хүмүүсийг мэргэжлийн хувьд ангилан харвал, санхүү НББ, эдийн засаг, бизнес худалдааны мэргэжилтэй хүмүүс 28.7%, бусад, хувиараа бизнес эрхлэгчид 25.3%, үлдсэн 46.0% нь багш, инженер, эмч, хууль, цэрэг цагдаа гэсэн ангиллуудад хамаарч байна.

Зураг 2. Ажил эрхлэлтийн байдал




9.5% нь ажилгүй, гэртээ хүүхдээ хардаг, өвчтэй болон хөдөлмөрийн чадваргүй хүмүүс байна. Үүнээс ажилгүй боловч ажил хайж байгаа иргэд 2.7% нь. Үлдсэн 20.1%-ийг малчин, тэтгэврийн хүн, болон оюутан бүрдүүлж байна.

Судалгаанд хамрагдсан нийт 175 оюутны 87.4% нь их дээд сургуульд бакалаврын түвшинд суралцдаг бол үлдсэн 12.6% нь дунд сургууль, МСҮТ-д суралцдаг.

Орлого, зарлагын байдал


Нийт судалгаанд оролцогсдын 68.8% нь хувийн орлоготой бөгөөд орлогын голлох эх үүсвэрийг хувийн салбар болон улсын байгууллагын ажилтны цалин, мөн хувийн бизнесийн орлого бүрдүүлж байна.

Зураг 3. Орлогын гол эх үүсвэр



Орлого тус бүрийн хэмжээнд ямар эх үүсвэр голлон нөлөөлж байгааг авч үзвэл 420'000 хүртэлх орлоготой иргэдийн 25.3% нь Монголд амьдарч буй хүмүүсийн тусламжаар амьдардаг хүмүүс бол 700'000-1'100'000-ийн орлоготой хүмүүсийн 31.5% нь улсын байгууллагад ажилладаг хүмүүс. 1'100'001-3'000'000 ийн хооронд орлоготой хүмүүсийн 32.9%-ийг хувийн салбарын орон тооны ажилчид. 3'000'000-аас дээш орлоготой хүмүүсийн 63%-ийг хувийн бизнестэй хүмүүс бүрдүүлж байна.

Зураг 4. Орлогын хэмжээ



Хоол хүнс болон бусад хэрэгцээтэй зүйлсийг худалдаж авсны дараа 81.2%-д нь тодорхой хэмжээний мөнгө үлддэг бөгөөд 72.5% зарцуулахаасаа илүү ирээдүйн хэрэгцээ, тодорхойгүй нөхцөл байдалд зориулан хадгалдаг байна.




Зураг 5. Орлогын зарцуулалт



Хамгийн багадаа 1 сарын цалинтай нь дүйцэхүйц гэнэтийн зардал гарсан тохиолдолд 22.5% нь зээл авч зардлыг төлөх бол 13.9% нь энэ төрлийн зардал гарахад өөрсдийнх нь хадгаламжийн хэмжээ хангалттай хүрнэ гэж үзэж байна. 41.6% нь аль болох зээлээс зайлсхийж зарим хэрэгцээгээ багасгаж, илүүдэл мөнгөөр төлнө, эсвэл ойр дотнын хүмүүсээсээ тусламж авна гэсэн байна. Харин үлдсэн 22.0% нь яаж төлөхөө мэдэхгүй, яагаад ч төлж чадахгүй, хэлэхгүй байхыг илүүд үзнэ гэсэн хариултуудыг өгчээ.


Зураг 6. Гэнэтийн зардал гарахад хэрхэн шийдэх вэ?



Зээлжилт болон санхүүгийн төлөв байдал

Нийт судалгаанд оролцогсдын 67.5%-д ямар нэгэн байдлаар хоол хүнс болон бусад хэрэгцээгээ хангахад нь санхүүгийн асуудал тулгардаг бөгөөд энэхүү асуудлаа шийдэхийн тулд хэн нэгнээс мөнгө зээлэхэд хүрдэг байна.

Зураг 7. Зээлжилт



Нийт иргэдийн 71.4% нь буюу 3 хүн тутмын 2 нь ямар нэгэн байдлаар зээлтэй бөгөөд 21.7% нь 1 хүртэлх сарын орлоготой нь тэнцэх хэмжээний зээлтэй, 23.5% нь 2-12 сарын орлоготой нь дүйцэхүйц зээлтэй, 26.2% нь 12 сарын орлогоос нь илүү зээлтэй байна. Үүнээс нийт зээлтэй хүний 28.2% нь сүүлийн 12 сарын дотор 3 болон түүнээс дээш сарын хугацаагаар зээлийн эргэн төлөлтөө хоцроож байжээ.

Зураг 8. Өөрийн ирээдүйн санхүүгийн төлөв байдлын талаарх төсөөлөл

ЖИЛИЙН ДАРААХ САНХҮҮГИЙН БАЙДАЛ



ГЭНЭТИЙН ЗАРДЛЫГ ЗЭЭЛГҮЙГЭЭР ТӨЛӨХ ЧАДВАРТАА САНАА ЗОВНИЖ БАЙГАА ЭСЭХ



ӨНДӨР НАСТАЙ БОЛОХ ҮЕД ЗАРЛАГАА НӨХӨХ ЧАДВАРТАА САНАА ЗОВЖ БАЙГАА ЭСЭХ



Жилийн дараах санхүүгийн байдалдаа иргэдийн 16.3% нь санаа зовнилтой буюу одоогийн нөхцөл байдал нь муудна гэсэн хүлээлттэй байгааг харж болохоор байна. 2 жил үргэлжилсэн цар тахлын дараа эдийн засаг аажим сэргэж эхэлсэн ч 2022 он гарснаар ковидын омикрон хувилбар, Орос Украины зөрчилдөөн, төсөөлөшгүй өндөр инфляци гээд ирээдүйн нөхцөл байдал тодорхойгүй хэвээр үргэлжлэх төлөвтэй байгааг иргэд мөн мэдэрч хариу үйлдэл үзүүлж байгааг харж болно гэж бодож байна.

Судалгаанд оролцогчдын профайл мэдээллийн дэлгэрэнгүйг Хавсралт 1-ээс үзнэ үү.

САНХҮҮГИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ТАЛААРХ ОЙЛГОЛТ, ХЭРЭГЛЭЭ

Санхүүгийн бүтээгдэхүүний талаарх ерөнхий ойлголт улс даяар сайжирсан байгаа хэдий ч хэрэглээ төдийлөн сайн биш байгаа нь санхүүгийн хүртээмж муу байгааг харуулж байна. Нийт 8 санхүүгийн үйлчилгээ үзүүлдэг байгууллагын 14 төрлийн бүтээгдэхүүнээс иргэд данс шалгах, мөнгө шилжүүлэх үйлчилгээг хамгийн сайн мэддэг бөгөөд мөн судалгаанд оролцогсдын 75.1% нь эдгээр үйлчилгээг хэрэглэдэг. Үүний дараа банкны хадгаламж болон зээлийн үйлчилгээнүүдийн талаарх мэдээлэл сайн, хэрэглээ өндөр байна.

Харин ойлголт хамгийн муутай, тэр хэрээр хэрэглээ бага санхүүгийн үйлчилгээнүүдэд хадгаламж зээлийн хоршооны холимог хадгаламж, хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн үйлчилгээ орж байна.

Хүснэгт 2: Санхүүгийн бүтээгдэхүүний талаарх мэдлэг, хэрэглээ

БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ТӨРӨЛ	СОНСОЖ БАЙСАН, МЭДЭЭЛЭЛТЭЙ	ХЭРЭГЛЭДЭГ
Хөрөнгө оруулалт	60.9%	18.2%
Даатгал	77.9%	32.8%
Ипотекийн зээл	78.6%	25.5%
Банкны зээл	84.6%	45.3%
Даатгал	74.7%	34.0%
Банкны хадгаламж	85.4%	59.1%
Данс шалгах, мөнгө шилжүүлэх	88.3%	75.1%
ББСБ-ын зээл	67.9%	20.4%
Цахим зээл	69.1%	25.6%
Хадгаламж зээлийн хоршооны хадгаламж	49.5%	12.5%
Хувь хүмүүсээс авсан зээл	71.7%	34.2%
Ломбард болон өдрийн зээлийн үйлчилгээ	76.4%	26.1%
Хувийн хадгаламж	65.5%	28.6%
Крипто валют, цахим мөнгө	58.7%	21.4%

Энэхүү санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээнүүдийн талаарх ойлголт, хэрэглээний байдал нь оролцогчдын наснаас хамаарч харилцан адилгүй байгааг доорх хүснэгтээс харж болно.

Хүснэгт 3: Санхүүгийн бүтээгдэхүүний хэрэглээ, насны бүлгээр

	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	ДААТГАЛ	ИПОТЕК	БАНКНЫ ХАДГАЛАМЖ	БАНКНЫ ЗЭЭЛ	ЦАХИМ ЗЭЭЛ	ЛОМБАРД	КРИПТО
18-24 (GEN Z)	15.0%	21.3%	8.2%	45.1%	16.0%	20.7%	17.6%	27.0%
25-39 (MILLENNIALS)	14.0%	29.1%	23.8%	49.0%	40.5%	28.1%	23.0%	16.4%
40+	15.9%	27.7%	23.5%	50.2%	42.8%	15.3%	21.8%	15.3%

Gen Z буюу 18-24 насны залуучуудын хувьд даатгал, ипотека, банкны зээл, ломбард зэрэг бүтээгдэхүүнүүдийг бусад насны хүмүүсээс бага хэрэглэдэг. Харин хөрөнгө оруулалт (15.0%), цахим зээл (20.7%), криптовалютыг (27%) илүүтэй сонгож хэрэглэдэг байна.

Millennials буюу 25-39 насны хүмүүс даатгал, ипотека, зээл, цахим зээл, ломбард гээд санхүүгийн бүтээгдэхүүний дийлэнхийг жигд хэрэглэдэг боловч хөрөнгө оруулалт (14.0%), криптовалют (16.4%)-ыг арай бага хэрэглэх хандлагатай.

40 болон түүнээс дээш насны хүмүүс хөрөнгө оруулалт, даатгал, ипотека, банкны зээл, хадгаламж, ломбард зэрэг уламжлалт бүтээгдэхүүнүүдийг илүү сонгон хэрэглэдэг болохыг цахим зээл (15.3%), криптовалют (15.3%)-ын бага хэрэглээнээс харж болохоор байна.

Мөн дээрх санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээнүүдийн хэрэглээг ажил эрхлэлтийн байдлаар харьцуулж харвал хувийн хэвшлийн ажилтан, ОУБ-ын ажилтан, хувиараа бизнес эрхэлдэг хүмүүс хөрөнгө оруулалт болон даатгалын бүтээгдэхүүний хэрэглээ улсын дундажаас илүү байна. Мөн зээлийн бүтээгдэхүүнүүдэд ажил эрхлэлтийн ялгаа хамгийн их буюу банк, ББСБ, ипотекийн зээл төрийн алба, хувийн хэвшил, ОУБ-ын ажилтан болон хувиараа бизнес эрхлэгчдэд хамгийн хүртээмжтэй байгаа бол ажилгүй, тогтмол орлогогүй, тэтгэвэрт гарсан, оюутан гэх мэт хүмүүст уг зээлийн хүртээмж бага, хувь хүмүүсээс авах зээл, ломбардын үйлчилгээ илүү их хүртээмжтэй ажиглагдаж байна.

Бүс нутгийн хувьд Улаанбаатар хот хөрөнгө оруулалт, даатгалын бүтээгдэхүүнүүдийн хэрэглээгээр улсын дундажаас өндөр байсан бол зээлийн үйлчилгээг улсын дундажаас бага хэрэглэдэг байна. Аймгуудын хувьд Орхон, Дорноговь, Хөвсгөл аймгууд хөрөнгө оруулалт, даатгалын бүтээгдэхүүний хэрэглээ улсын дундажаас өндөр байсан бол Булган, Дундговь, Архангай аймгуудад хамгийн бага байв. Санхүүгийн бүтээгдэхүүнүүдийн хэрэглээ Булган аймагт хамгийн бага байсан бол Орхон аймагт хамгийн өндөр байна.

Дээрхээс харахад санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээний хэрэглээнд нас, ажил эрхлэлтийн байдал, оршин суугаа бүс нутаг зэрэг хүчин зүйлс нөлөөлдөг болох нь ажиглагдаж байна.

САНХҮҮГИЙН БОЛОВСРОЛЫН ЧАДАМЖ

Санхүүгийн боловсролын чадамжтай байснаар өөрийн зорилгод тохирсон санхүүгийн бүтээгдэхүүнийг сонгон ашиглаж ашиг тусыг нь хүртэх, өрийн дарамтад орохгүй байх, тодорхойгүй санхүүгийн эрсдэлээс өөрийгөө хамгаалах, санхүүгийн залилангийн хохирогч болохоос сэргийлэх зэрэг ач холбогдолтой.


Санхүүгийн боловсролын чадамжийг үнэлэхдээ 1-20 хүртэлх оноогоор хэмжиж, тодорхойлсон бөгөөд дараах бүрдэл хэсгүүдийн нийлбэрээр тооцоологдоно. Үүнд:

1. Санхүүгийн хандлага (4 хүртэлх оноо)
2. Санхүүгийн мэдлэг (9 хүртэлх оноо)
3. Эдийн засгийн мэдлэг (7 хүртэлх оноо)


Эдгээр 3 хувьсагч тус бүрийн оноо хамаарагдах бүлэг асуултуудын нийлбэр оноогоор тодорхойлно.

Нийт 35 асуултаар үнэлж үзэхэд судалгаанд оролцсон Монгол улсын нийт иргэдийг төлөөлөх оролцогчдын санхүүгийн боловсролын чадамжийн дундаж оноо 9.9 буюу байж болох дээд хэмжээний 49.5 хувьтай байна.

Зураг 9. Санхүүгийн боловсролын чадамж, улсын дундаж



Зураг 10. Санхүүгийн боловсролын чадамж, улсын дундаж



Байршлаар нь авч үзвэл Улаанбаатар хот (10.3) болон Хөвсгөл (11.5), Дархан-Уул (11.1), Булган (11.1), Ховд (10.9), Дорноговь (10.5), Сэлэнгэ (10.2), Увс (10.2), Завхан (10.0), Баянхонгор (10.0) аймгийн иргэд улсын дунджаас илүү өндөр оноотой байна. Үүнээс харахад, санхүүгийн боловсролын чадамжт хот болон орон нутгийн хооронд статистикийн хувьд мэдэгдэхүйц ялгаа харагдахгүй байна. Санхүүгийн боловсролын чадамжийн түвшин хамгийн бага аймгуудад Орхон (8.4), Архангай (8.4), Өмнөговь (8.7) аймгууд багтаж байна.

Ажил эрхлэлтийн байдлаар авч үзвэл хувийн хэвшил, төрийн алба, олон улсын байгууллага, төрийн бус байгууллагад ажиллагсад болон хувиараа бизнес эрхлэгчдийн санхүүгийн хандлага, санхүүгийн мэдлэг, эдийн засгийн мэдлэг, санхүүгийн боловсролын чадамж зэрэг үзүүлэлтүүд улсын дунджаас дээгүүр байна. Оюутнуудын хувьд санхүүгийн мэдлэг, эдийн засгийн мэдлэгийн хувьд улсын дунджаас дээгүүр байгаа хэдий ч санхүүгийн хандлагын хувьд улсын дунджаас бага байгаа нь санхүү, эдийн засгийн мэдлэг байгаа атлаа хадгалах, хуримтлуулах, төлөвлөх хандлага бага байгаагаар тайлбарлагдаж байна.

Санхүүгийн боловсролын чадамж нь санхүүгийн мэдлэг, эдийн засгийн мэдлэг, санхүүгийн хандлага, гэсэн 3 хэсгээс бүрдэх тул эдгээр бүрдэл хэсэг тус бүрийг дараагийн хэсгүүдэд нарийвчлан авч үзье.

САНХҮҮГИЙН МЭДЛЭГ

Санхүүгийн мэдлэг нь санхүүгийн чадамжийн хамгийн чухал бүрдэл хэсэг бөгөөд хувь хүмүүст санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээнүүдийг харьцуулж, ямагт мэдээлэлтэй байж, өөрийн санхүүгийн нөхцөл байдалд нийцтэй зөв шийдвэр гаргахад тусалдаг. Санхүүгийн суурь мэдлэг, тооцооллын энгийн чадвартай байснаар хувь хүн зах зээлийн нөхцөл байдал, төрөл төрлийн мэдээлэл дундуур өөрийн санхүүгийн байдлыг итгэлтэйгээр удирдан чиглүүлэх чадвартай болдог.

Санхүүгийн мэдлэг хэсгийг үнэлэхдээ хувь хүний санхүүгийн шийдвэр гаргахад хамгийн тустай гэж үздэг талбаруудын мэдлэгийг шалгах 7 асуултаар шалгах бөгөөд зөв хариулт болгон 1 оноотой тул хамгийн ихдээ нийт 7 оноо авах боломжтой юм. Эдгээр асуултуудад зөв хариулахын тулд судалгаанд оролцогчдоос инфляц, мөнгөний цаг хугацааны үнэ цэнэ, урт хугацааны энгийн болон хуримтлагдсан хадгаламж, хөрөнгө оруулалтын өгөөж ба эрсдэл зэрэг санхүүгийн ойлголтуудын талаар суурь мэдлэг шаардана.

Санхүүгийн мэдлэгийг үнэлэх асуултуудыг харьцуулж харвал худалдан авалт хийхдээ энгийн хүүгийн тооцоолол хийж, харьцуулан шийдвэр гаргах чадварын асуулт хамгийн өндөр зөв хариулттай буюу 80.6%, нийлмэл хүүгийн талаарх асуулт хамгийн бага зөв хариулттай буюу 28.4% байв. Харин энгийн хүүгийн тухай зөв хариулт 42.5% байсан бөгөөд судалгаанд оролцогчдын энгийн хүүгийн талаарх мэдлэгтэй иргэдийн 64.9% нь нийлмэл хүүгийн талаар мэдлэгтэй, үлдсэн 35.1% нь энгийн хүүгийн талаар мэддэг хэдий ч нийлмэл хүүгийн талаар мэддэггүй байна.

Мөн мөнгөний худалдан авах чадварт инфляц нөлөөлөх тухай асуултад судалгаанд оролцогчдын 38.9%, даатгалын бүтээгдэхүүний талаарх асуултад 70.5% нь тус тус зөв хариулсан байна. Судалгаанд оролцогчдын 63.0% нь хувьцааны талаар зөв хариулсан хэдий ч эрсдэл ба өгөөжийн тухай ойлголт 50.3%, эрсдэлийг тархаан байршуулах тухай ойлголт 44.7%, хамгийн эрсдэлтэй хөрөнгө оруулалтын тухай ойлголт 42.9% байв. Үүнээс

харахад судалгаанд оролцогчдын хүү болон хувьцааны талаарх зөвхөн анхан шатны буюу суурь асуултуудад илүү зөв хариулж, арай гүнзгий асуултуудад буруу хариулах хандлагатай байна.


Мөн судалгаанд оролцогчдын 42.9% нь криптовалютыг хамгийн эрсдэл өндөртэй хөрөнгө оруулалт гэж оновчтой хариулсан байна. 2021 онд болсон крипто зах зээлийн эрчимтэй хөдөлгөөний үр дүнд иргэд крипто валютын талаарх тодорхой ойлголттой болсон бөгөөд эрсдэлтэй хөрөнгө оруулалт болохыг ч ухаарсан байгааг харж байна.

Хүснэгт 4: Санхүүгийн мэдлэгийн асуултуудад зөв хариулсан байдал

САНХҮҮГИЙН МЭДЛЭГ		Зөв хариулт (%)	
Асуулт 1	Мөнгөний худалдан авах чадварт инфляц нөлөөлөх нь	38.9%	
Асуулт 2	Энгийн хүүгийн талаарх ойлголт	42.5%	
Асуулт 3	Нийлмэл хүүгийн талаарх ойлголт	28.4%	
Асуулт 4	Харьцуулах шийдвэр гаргалт	80.6%	
Асуулт 5	Эрсдэл ба өгөөжийн талаарх ойлголт	50.3%	
Асуулт 6	Даатгалын бүтээгдэхүүний талаар	70.5%	
Асуулт 7	Хувьцааны талаарх ойлголт	63.0%	
Асуулт 8	Эрсдэлтэй хөрөнгө оруулалт	Крипто валют	42.9%
		Хувьцаа	17.7%
		Бонд	11.9%
		ХБҮЦ ³	5.3%
		Үл хөдлөх хөрөнгө	3.8%
Асуулт 9	Эрсдэлийн тархаан байршуулалтын талаарх ойлголт	44.7%	

Сэдэв тус бүрийн үр дүнг нэгтгэн харвал, улсын хэмжээнд санхүүгийн мэдлэг дунджаар 4.7 байгаа нь нийт авбал зохих 9 онооны 52.1% юм. Үүнд Улаанбаатар (5.1) хот болон Дархан (5.4), Хөвсгөл (5.3), Дорноговь (5.2), Баянхонгор (5.1), Дорнод (5.0), Ховд (5.0), Сэлэнгэ (4.9), Дундговь (4.8), Хэнтий (4.8), Увс (4.8) аймгууд улсын дунджаас дээгүүр байсан бол Баян-Өлгий (3.9), Архангай (3.9), Орхон (3.8) аймгууд хамгийн бага оноотой байна.

Зураг 11. Санхүүгийн мэдлэгийн улсын дундаж үзүүлэлт



³ Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас

Санхүүгийн мэдлэгийн түвшнийг насны ангиллаар нь харвал, 18-24 насны залуучуудын мэдлэг 5.4 оноо буюу 60%, 25-39 насны хүмүүсийн мэдлэг 4.8 оноо буюу 53.3%, 40 болон түүнээс дээш насны хүмүүсийн мэдлэг 4.7 оноо буюу 52.2% байна. Үүнээс харахад санхүүгийн мэдлэг, нас хоёрын хооронд урвуу хамааралтай буюу нас ахих тусам санхүүгийн мэдлэгийн түвшин буурч байна.

Зураг 12. Санхүүгийн мэдлэг, насны ангиллаар



ЭДИЙН ЗАСГИЙН МЭДЛЭГ

Эдийн засгийн мэдлэгийг үнэлэх хэсэг нь нийт 7 асуулттай бөгөөд зөв хариулт бүр 1 оноо, хамгийн ихдээ 7 оноо авах боломжтой. Асуултуудад Монголбанкны үйл ажиллагаа, мөнгөний бодлого, инфляц, валютын ханш, ДНБ зэрэг эдийн засгийн үндсэн ойлголтуудыг хамруулсан.

Эдийн засгийн мэдлэгийг үнэлэх доорх асуултуудын хариултыг харьцуулж харвал инфляцын талаарх асуултад хамгийн өндөр буюу оролцогчдын 67.4% нь зөв хариулжээ. Гэвч ДНБ-ний талаарх мэдлэг маш тааруу буюу ердөө 8 хүний 1 нь ДНБ-ийн талаар мэддэг байна. Өөрөөр хэлбэл судалгаанд оролцогчдын 12.1% нь ДНБ-ийн талаарх асуултад зөв хариулсан байна. Угтаа бол тухайн улсын эдийн засгийн хүчин чадлыг хэмждэг гол үзүүлэлт нь ДНБ юм.

Мөн Монголбанкны мөнгөний бодлогын талаарх мэдлэг 58.1%, бодлогын хүүгийн талаарх ойлголт 34.6% байгаагаас харахад мөнгөний бодлогын талаарх ерөнхий ойлголттой иргэдийн 2/3 нь мөнгөний бодлогын хэрэгслийн талаар мэдлэгтэй, 1/3 нь мөнгөний бодлогын хэрэгсэл болох бодлогын хүүгийн талаар мэдлэггүй байна.

Валютын ханш хэрхэн тогтдог тухай ойлголт 42.5%, Монголбанкны үндсэн зорилтын тухай ойлголт 54.6%, банк хоорондын мөнгөний гүйлгээний талаарх ойлголт 44.3%-тай байв.

Хүснэгт 5: Эдийн засгийн мэдлэгийн зөв хариулт

ЭДИЙН ЗАСГИЙН МЭДЛЭГ		Зөв хариулт (%)
Асуулт 1	Мөнгөний бодлогын талаарх ойлголт	58.1%
Асуулт 2	Бодлогын хүүгийн талаарх ойлголт	34.6%

Асуулт 3	Инфляцын талаарх ойлголт	67.4%
Асуулт 4	Валютын ханшны талаарх ойлголт	42.5%
Асуулт 5	Монгол банкны үндсэн зорилтын тухай	54.6%
Асуулт 6	Мөнгөний гүйлгээг аль банк хянадаг вэ?	44.3%
Асуулт 7	ДНБ-ний талаарх ойлголт	12.1%

Улсын хэмжээнд нийт иргэдийн эдийн засгийн мэдлэг 3.03 оноо буюу 43.3%-тай байгаа нь санхүүгийн боловсролын чадамжээс хамгийн муу нь болж байна. Бүс нутгаар авч үзвэл, Улаанбаатар хот (3.1) болон Хөвсгөл (4.0), Булган (4.0), Завхан (3.1), Сэлэнгэ (4.0) аймгууд улсын дунджаас дээгүүр байсан бол Хэнтий (2.0), Говь-Алтай (2.4), Өмнөговь (2.4) аймгууд хамгийн бага оноотой байна.

Зураг 13. Эдийн засгийн мэдлэгийн улсын дундаж үзүүлэлт



Насны бүтцийн хувьд иргэдийн дундах эдийн засгийн мэдлэг онцын ялгаагүй буюу жигдхэн байгаагаас нас бол эдийн засгийн мэдлэгийн хувьд тодорхойлогч хүчин зүйл биш болохыг харж болно. Харин бүс нутгийн хувьд том ялгаа байгааг Хөвсгөл (4.0) болон Говь-Алтай (2.4), Өмнөговь (2.4) аймгуудын жишээнээс ажиглагдаж байна.

Зураг 14. Эдийн засгийн мэдлэг, насны ангиллаар



САНХҮҮГИЙН ХАНДЛАГА


Санхүүгийн зөв шийдвэр гаргах, цаашлаад хувь хүний санхүүгийн сайн сайханд хүрэхэд санхүүгийн ухамсар, мэдлэг, ур чадвар, хандлагын хослол шаардлагатай хэмээн OECD тодорхойлсон байдаг. Өөрөөр хэлбэл, санхүүгийн шийдвэр гаргахад хувь хүмүүсийн санхүүгийн мэдлэг, чадвараас илүүтэй хандлага чухал нөлөөтэй гэсэн үг юм.

Судалгааны энэхүү хэсэг нь оролцогчдын мөнгөнд хандах хандлага, ирээдүйгээ төлөвлөхөд чиглэсэн 4 асуултыг багтаасан болно. Үүнд:

1. Санхүүгийн шийдвэрээ өөрөө гаргадаг эсэх;
2. Худалдан авалт хийхдээ хүсэл хэрэгцээгээ ялгадаг эсэх;
3. Санхүүгээ 6 сараас дээш хугацаанд төлөвлөдөг эсэх;
4. Ирээдүйн тодорхойгүй нөхцөл байдалд зориулж нөөцтэй байдаг эсэх;

Дээрх 4 асуулт судалгаанд оролцогчийг бүрэн тодорхойлж байвал санхүүгийн эерэг хандлагатай гэж дүгнэж болно гэж дүгнэсэн.

Зураг 15. Санхүүгийн төлөвлөдөг эсэх



Судалгаанд оролцогчдын 71.6% нь санхүүгээ төлөвлөдөг нь сайн мэдээ боловч 58.9% нь богино хугацаанд л санхүүгээ төлөвлөдөг, 37.2% нь 1 сар хүртэлх хугацаагаар буюу цалингаас цалингийн хооронд төлөвлөдөг болохыг судалгаанаас харж болохоор байна. Үүнээс дүгнэхэд маргаашаас илүү өнөөдрөө харж амьдардаг хандлага одоог хүртэл хэвээр байна.

Мөн судалгаанд оролцогчдын 82.5% нь ирээдүйдээ зориулж тодорхой хэмжээнд мөнгө хадгалдаг бол 77.7% нь бага хэмжээний гэлтгүй хадгалахыг хичээдэг, 79.2% нь онцгой нөхцөл байдал, төлөвлөгдөөгүй зардалд зориулж мөнгөний нөөцтэй байхыг хичээдэг байна. Дээрх 3 мэдэгдлээс онцгой нөхцөл байдалд зориулж мөнгө хадгалдаг нь санхүүгийн хандлагыг хэмжих гол үзүүлэлт гэж авч үздэг.

Хадгалах, хуримтлал үүсгэх хандлага хэдийгээр өндөр байгаа хэдий ч нийт иргэдийн 51.3% нь бодит хадгаламжтай байна. Өөрөөр хэлбэл 4 иргэн тутмын 3 нь хуримтлал үүсгэж, мөнгө хадгалахыг хичээдэг боловч 2 нь хадгаламжтай байна. Мөн хадгаламжийн дүн маш бага

буюу иргэдийн олонхи нь 3 сая хүртэлх төгрөгийн хуримтлалтай болох нь банкин дахь иргэдийн хадгаламжийн тархалтын судалгаанаас харагддаг.⁴

Зураг 16. Хуримтлал үүсгэх хандлага

БИ ИРЭЭДҮЙД ЗОРИУЛЖ МӨНГӨ
ХАДГАЛАХЫГ ХИЧЭЭДЭГ

Тийм, маш их



Тийм, тодорхой хэмжээнд



БИ БАГА ХЭМЖЭЭНИЙ МӨНГӨ
БАЙСАН Ч ХАДГАЛАХЫГ ХИЧЭЭДЭГ

Тийм, маш их



Тийм, тодорхой хэмжээнд



БИ ОНЦГОЙ НӨХЦӨЛ БАЙДАЛ, ТӨЛӨВЛӨӨГҮЙ
ЗАРДАЛД ЗОРИУЛЖ НӨӨЦТЭЙ БАЙХЫГ ХИЧЭЭДЭГ

Тийм, маш их




Тийм, тодорхой хэмжээнд



Улсын хэмжээнд санхүүгийн хандлага 2.3 байгаа нь нийт авбал зохих 4 онооны 56.3% байна. Орон нутгаар харьцуулж үзвэл Баян-Өлгий (2.7), Булган (2.6), Увс (2.5), Ховд (2.4), Сүхбаатар (2.4), Хэнтий (2.3), Завхан (2.3), Дархан-Уул (2.3), Өмнөговь (2.3), Дорноговь (2.3), Баянхонгор (2.2), Сэлэнгэ (2.2), Говьсүмбэр (2.2) аймгууд улсын дунджаас дээгүүр байсан бол Дундговь (2.0), Орхон (1.9), Өвөрхангай (1.9) аймгууд хамгийн бага оноотой байна. Улаанбаатар хот мөн 2.1 байж улсын дунджаас тааруу үр дүнг харуулсан нь орон нутгийн иргэдийн дунд санхүүгийн сахилга бат илүү сайн байна гэж дүгнэж болохоор байна.

Зураг 17. Санхүүгийн хандлагын улсын дундаж үзүүлэлт

Улсын дундаж үзүүлэлт



Насны бүтцээр авч үзвэл 18-24 насны залуучуудын санхүүгийн хандлага улсын дунджаас доогуур байгааг харвал уг насны буюу Gen Z үеийнхэн бусад насны хүмүүстэй

⁴ СЗХ, Санхүүгийн Хүртээмж-Хөгжил Санаачилга, Иргэдийн санхүүгийн чадамжийн судалгаа, 2021

харьцуулахад санхүүгийн шийдвэрээ бие даан гаргах хандлага болон санхүүгээ урт хугацаанд буюу 6 сараас дээш хугацаагаар төлөвлөх хандлага бага байна. Нас ахих тусам хүмүүс санхүүгээ урт хугацаагаар төлөвлөх, бие даан шийдвэр гаргах, тодорхойгүй нөхцөлд зориулан нөөцтэйг байхыг эрмэлзэх зэрэг хандлагууд илүүтэй ажиглагдаж эхэлдэг байна.

Зураг 18. Санхүүгийн хандлага, насны ангиллаар




Санхүүгийн чухал шийдвэр гаргахдаа өмнө зөвлөгөө авдаг эсэх тухайд нийт судалгаанд оролцогсдын 81.8% нь их бага хэмжээгээр нэмэлт зөвлөгөө авдаг гэж хариулсан бөгөөд 5 хүн тутмын 1 (18.2%) нь санхүүгийн чухал шийдвэр гаргахдаа зөвлөгөө авдаггүй байна. Мөн судалгаанд оролцогчдын 70.3% нь мөнгө, санхүүгээ удирдах өөрийн чадвартаа итгэлтэй байдаг гэдэгээ илэрхийлжээ.

Зураг 19. Санхүүгийн шийдвэр гаргахдаа зөвлөгөө авдаг эсэх



Зураг 20. Хэнээс санхүүгийн зөвлөгөө авдаг вэ?



Санхүүгийн зөвлөгөө авдаг эх сурвалжийн хувьд эхнэр нөхөр, хамтран амьдрагч (20.1%), гэр бүлийн бусад гишүүн, найз нөхөд (21.5%), банкны ажилтан, мэргэжилтэн (19%) нар хамгийн түгээмэл эх сурвалжууд байна. Мөн түүнчлэн судалгаанд оролцогчдийн 8.4% нь хамтран ажиллагсад, ажил олгогчдоос, 5.3% нь нийгэмд нөлөө бүхий хүн буюу инфлюенсэрүүдээс, 6.2% нь бусад эх сурвалжуудаас зөвлөгөө, мэдээлэл авч санхүүгийн шийдвэр гаргадаг байна. Өөрөөр хэлбэл 5 хүн тутмын 2 (41.6%) нь эргэн тойрны хүмүүс болох аав ээж, эхнэр, нөхөр, ах дүү, гэр бүлийн гишүүдээс санхүүгийн зөвлөгөө авдаг бол ердөө 19% нь л мэргэжлийн хүнээс зөвлөгөө авч, 17.5% нь бусдаас огт зөвлөгөө авдаггүй байна.

Аливаа хэлбэрийн санхүүгийн луйвар, залилангаас таньж, түүнээс сэргийлэх чадварыг үнэлэх зорилгоор бид “Хэрэв хэн нэгэн таньд багахан хэмжээний хураамж төлж, их хэмжээний мөнгө олох боломж санал болговол ямар арга хэмжээ авах вэ?” гэсэн асуултыг тавьсан бөгөөд үр дүнд нь судалгаанд оролцогчдын 20.8% нь мэргэжилтнээс зөвлөгөө авна, 18.8% нь тухайн баг, хүмүүсийг судалж шийдвэр гаргана, 16.0% нь найз нөхөд, гэр бүлийнхнээс зөвлөгөө авна, 12.7% нь хөрөнгө оруулахгүй гэсэн хариуг өгсөн бол 18.3% нь яахаа мэдэхгүй, 3.5% нь шууд хөрөнгө оруулна гэж хариулжээ.


Зураг 21. Санхүүгийн луйвар, залилангаас сэргийлэх хандлага

БАГА ХЭМЖЭЭНИЙ ХУРААМЖ ТӨЛЖ, ИХ ХЭМЖЭЭНИЙ МӨНГӨ ОЛОХ БОЛОМЖ САНАЛ БОЛГОВОЛ ЯМАР АРГА ХЭМЖЭЭ АВАХ ВЭ?



Харин сүлжээний бизнес, санхүүгийн луйврыг ялган таньж мэдэх тухай хаанаас, ямар эх сурвалжаас мэдээлэл авдаг тухайд 9.9% нь мэргэжлийн хүнээс, 24.2% нь олон нийтийн сүлжээнээс, 3.4% нь СЗХ, Монголбанкнаас, 27.3% нь ойр дотны хүмүүсээс гэж хариулсан бол 27.3% нь энэ талаар огт мэдээлэл авч байгаагүй гэсэн хариултыг өгчээ.


Зураг 22. Сүлжээний бизнес, санхүүгийн луйврыг танихдаа хаанаас мэдээлэл авдаг вэ?




Дээрх асуултуудын хариултаас харахад иргэд аливаа хэлбэрийн санхүүгийн луйвар, залилангийн шинжтэй үйлдэлд мэргэжлийн хүнрүү хандах, зөвлөгөө авах хандлага тун бага байдаг бөгөөд аль болох өөрийн ойр дотны хүмүүст хандан зөвлөгөө авч, олон нийтийн сүлжээнээс мэдээлэл авах хандлагатай байна.

Мөн судалгаанд оролцогчдын 16.5% нь Монголбанкны албан ёсны мэдээллийн сувгуудаас, 21.2% нь олон нийтийн сүлжээнээс, 26.5% нь телевиз, радианоос, 8.8% нь сонин сэтгүүлээс, 11.4% нь гэр бүл, найз нөхдийн хүрээлээс тус тус Монголбанкны тухай болон бусад холбогдох мэдээллүүдийг авч чаддаг гэж хариулсан бол 10.4% нь Монголбанкны тухай болон холбоотой бусад мэдээллийг огт авч чаддаггүй байна. Эндээс үзвэл иргэд, олон нийт санхүүгийн шийдвэр гаргахад шаардлагатай мэдээлэл, зөвлөгөөг өөрт хэрэгцээтэй цаг хугацаандаа албан ёсны, мэргэжлийн эх сурвалжаас олж авч чаддаггүй бөгөөд мэргэжлийн байгууллагууд уг төрлийн мэдээллийн хүртээмжийг сайжруулах шаардлагатай харагдаж байна.

Зураг 23. Монголбанктэй холбоотой мэдээллийн эх сурвалж



Зураг 24. Санхүүгийн боловсрол олгох сургалтыг аль хэлбэрээр авахыг илүүд үзэх вэ?



ДҮГНЭЛТ

Монгол улсын 21 аймаг, хотод 15-69 насны 1947 хүнийг хамруулсан санхүүгийн боловсролын чадамжийн түвшинг тогтоох уг судалгааны үр дүнд иргэд, олон нийтийн санхүүгийн боловсролын чадамжийн түвшин 9.9 оноо буюу авч болох боломжит хамгийн өндөр оноо (20)-ны 49.5% байна. Улаанбаатар хот (10.3) болон Хөвсгөл (11.5), Дархан-Уул (11.1), Булган (11.1), Ховд (10.9), Дорноговь (10.5), Сүхбаатар (10.3), Сэлэнгэ (10.2), Увс (10.2), Завхан (10.0), Баянхонгор (10.0) аймгууд улсын дунджаас илүү өндөр оноотой байна.

- **Санхүүгийн мэдлэг:** Судалгаанд оролцсон нийт иргэдийн санхүүгийн мэдлэгийн дундаж оноо боломжит 9 онооноос 4.7 буюу 52.1% байна. Үүнд Gen Z үеийнхэн бусад насны ангиллаас илүү буюу 5.2 оноо (58.2%) байсан бөгөөд нас ахих тусам санхүүгийн мэдлэг буурч байв. Мөн Улаанбаатар (5.1) хот болон Дархан (5.4), Хөвсгөл (5.3), Дорноговь (5.2), Баянхонгор (5.1), Дорнод (5.0), Ховд (5.0), Сэлэнгэ (4.9), Дундговь (4.8), Хэнтий (4.8), Увс (4.8) аймгууд улсын дунджаас дээгүүр байсан бол Баян-Өлгий (3.9), Архангай (3.9), Орхон (3.8) аймгууд хамгийн бага оноотой байв.
- **Эдийн засгийн мэдлэг:** Судалгаанд оролцсон нийт иргэдийн эдийн засгийн мэдлэгийн дундаж оноо боломжит 7 онооноос 3.1 буюу 44.2% байна. Насны бүлгийн хувьд иргэдийн дундах эдийн засгийн мэдлэг ялгаагүй байсан бол бүс нутгийн хувьд том ялгаа байгаа нь Хөвсгөл (4.0) болон Говь-Алтай, Өмнөговь (2.4) аймгуудаас харагдаж байна.
- **Санхүүгийн хандлага:** Улсын хэмжээнд санхүүгийн хандлагын дундаж оноо 2.25 байгаа нь нийт авбал зохих 4 онооны 56.3% байна. Үүнд 11 аймгийн үр дүн улсын дунджаас өндөр байсан бол Улаанбаатар хот (2.1) улсын дунджаас доогуур байв.

OECD-ээс 2021 онд хуучин ЗХУ-ын бүрэлдэхүүн орнуудад хийсэн санхүүгийн боловсролын судалгаанд⁵ Төв Азийн орнууд болох Казакстан, Узбекистан, Киргиз, Тажикстан орнуудын санхүүгийн боловсролын чадамж тус бүр 59.6%, 59.9%, 55.4%, 51.1% байсан бөгөөд Төв Азийн орнуудын санхүүгийн боловсролын дундаж 56.5% байсан нь манай улстай харьцуулахад 7.0%-иар өндөр үзүүлэлт юм.

Тэдгээрээс Монгол улсын байгаль цаг уурын нөхцөл, уул уурхайд түшиглэсэн эдийн засаг гээд олон талаараа ижил төстэй Казакстан улсын иргэдийн санхүүгийн мэдлэгийг харьцуулан харвал, иргэдийн санхүүгийн мэдлэг 60%, санхүүгийн хандлага 65.4% ба санхүүгийн боловсролын чадамж 59.6% байжээ. Энэхүү үзүүлэлт нь манай улстай харьцуулахад 10 орчим хувиар өндөр байна.

Мөн 2020 онд OECD-ээс хийсэн олон улсын санхүүгийн боловсролын судалгаанд⁶ оролцсон Ази, Европ, Латин Америкийн 26 орны дундажаар санхүүгийн мэдлэг 62.9%, санхүүгийн хандлага 58.9%, боловсролын чадамж 60.5% байжээ. Энэхүү үр дүнг манай улсын санхүүгийн боловсролын чадамжтай харьцуулахад мөн адил 11 хувиар өндөр байна.

Санхүүгийн боловсролын чадамжид насны бүлэг болон ажил эрхлэлтийн байдал чухал нөлөөтэй хүчин зүйлс байна. Насны хувьд нас ахих тусам санхүүгийн хандлага нэмэгддэг хэдий ч санхүү, эдийн засгийн мэдлэг сул байгаа бол ажил эрхлэлтийн хувьд тогтмол

⁵ <https://www.oecd.org/daf/fin/financial-education/Financial-literacy-levels-in-the-commonwealth-of-independent-states-in-2021.pdf>

⁶ <https://www.oecd.org/financial/education/oecd-infe-2020-international-survey-of-adult-financial-literacy.pdf>

цалин орлоготой, тогтвортой хөдөлмөр эрхэлдэг хүмүүс тогтвортой орлогогүй хүмүүстэй харьцуулахад санхүүгийн боловсролын чадамж өндөртэй байна.

Санхүүгийн бүтээгдэхүүний талаарх ойлголт улс даяар сайн байгаа хэдий ч хэрэглээ төдийлөн сайн биш байгаа нь санхүүгийн хүртээмж хангалтгүй байх нэг шалтгаан болж байна. Нийт 8 санхүүгийн үйлчилгээ үзүүлдэг байгууллагын 14 төрлийн бүтээгдэхүүнээс иргэд данс шалгах, мөнгө шилжүүлэх үйлчилгээг хамгийн сайн мэддэг бөгөөд мөн судалгаанд оролцогсдын 75.1% нь энэхүү үйлчилгээг хэрэглэдэг. Үүнээс харахад, арилжааны банкуудын үйлчилгээг ихэвчлэн сайн мэддэг боловч даатгалын компаниуд, бичил санхүүгийн байгууллага, болон хадгаламж зээлийн хоршоо зэрэг байгууллагуудын үзүүлдэг илүү өргөн хүрээний санхүүгийн үйлчилгээний талаарх мэдлэг хязгаарлагдмал байна.

Иргэдийн санхүүгийн мэдлэг эдийн засгийн мэдлэгээс илүү сайн үр дүнтэй гарсан хэдий ч инфляци, ДНБ гэх мэт зарим төрлийн сэдвүүдийн талаарх мэдлэг маш ерөнхий, сонсох төдийд байсан бөгөөд уг мэдлэгийг өдөр тутмын амьдралдаа хэрэгжүүлж чадахгүй байна.

Судалгаанд оролцсон иргэдийн 70.3% нь мөнгө, санхүүгээ удирдах өөрийн чадвартаа итгэлтэй байдаг хэмээн хариулсан. Гэвч бодит байдал дээр тэдгээр иргэдийн санхүүгийн мэдлэг, эдийн засгийн мэдлэг, болон санхүүгийн хандлага хангалтгүй буюу 49.5%-тай байна. Үүнд нөлөөлөгч хүчин зүйлсийг дурдвал:

- Орлого нь зарлагаа нөхөж чадахгүй байгаатай холбоотойгоор иргэдийн 67.5%-д ямар нэгэн байдлаар хоол хүнс болон бусад хэрэгцээгээ хангахад нь асуудал тулгардаг бөгөөд энэхүү асуудлаа шийдэхийн тулд хэн нэгнээс мөнгө зээлэхэд хүрдэг.
- Санхүүгийн байгууллагуудын өргөн хүрээний үйлчилгээний талаарх мэдлэг арилжааны банкны зээл, хадгаламжаар хязгаарлагдаж байна.
- Бусад санхүүгийн мэдлэг, хандлагаасаа эдийн засгийн мэдлэг хамгийн тааруу гэсэн үр дүн гарсан. Үүнээс иргэд макро, микро орчны нөхцөл байдалд тулгуурлан санхүүгийн хувьд хариу үйлдэл үзүүлж чаддаггүй гэх дүгнэлтэд хүрч болно.

Мэдлэгийг багц хөтөлбөртэй сургалтаар дамжуулж авч болно, эсвэл санхүүгийн байгууллагууд үйлчилгээ үзүүлэхийн хажуугаар нийгмийн хариуцлагын хүрээнд хэрэглэгч нартаа санхүүгийн боловсрол олгох замаар иргэдийн санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх боломжтой гэж дүгнэж байна.

Мөн иргэд, олон нийтийн санхүүгийн шийдвэр гаргахдаа авдаг зөвлөгөө, мэдээллийн эх сурвалжаас харахад судалгаанд оролцогчдын 17.5% нь хэнээс ч зөвлөгөө авдаггүй бол, 41.6% нь эргэн тойрны хүмүүс болох ээж, аав, эхнэр, нөхөр болон гэр бүлийн гишүүдээс, 19% нь мэргэжлийн хүнээс зөвлөгөө авахыг эрмэлздэг байна. Мэдээллийн эх сурвалжийн хувьд судалгаанд оролцогчдын тал (51.5%) нь ойр дотны хүмүүс болон олон нийтийн сүлжээнээс санхүүгийн мэдээлэл авдаг бол 27.3% нь энэ талаар огт мэдээлэл авч чаддаггүй байна. Эдгээрээс харахад иргэд, олон нийтийн санхүүгийн шийдвэр гаргахад нөлөөлөх гол хүчин зүйл нь ойр дотны хүмүүс болон олон нийтийн сүлжээнээс авч буй мэдээлэл, зөвлөгөө байгаа тул аливаа санхүүгийн зөвлөгөө, мэдээлэл, сургалтуудыг цахимжуулах, хүртээмжтэй болгох шаардлагатай байна.

Хавсралт 1. Судалгаанд оролцогчдын байршил, насны бүлгээр

ОРОЛЦОГЧИЙН БАЙРШИЛ	Насны бүлэг							
	18-24		25-39		40+		Нийт	
	Count	%	Count	%	Count	%	Count	%
Улаанбаатар	160	8.2%	226	11.6%	314	16.1%	700	36.0%
Архангай	21	1.1%	32	1.6%	17	0.9%	70	3.6%
Баян-Өлгий	10	0.5%	36	1.8%	30	1.5%	76	3.9%
Баянхонгор	9	0.5%	28	1.4%	28	1.4%	65	3.3%
Булган	6	0.3%	39	2.0%	4	0.2%	49	2.5%
Говь-Алтай	5	0.3%	19	1.0%	20	1.0%	44	2.3%
Говьсүмбэр	2	0.1%	6	0.3%	5	0.3%	13	0.7%
Дархан-Уул	7	0.4%	12	0.6%	74	3.8%	93	4.8%
Дорноговь	5	0.3%	27	1.4%	20	1.0%	52	2.7%
Дорнод	6	0.3%	26	1.3%	29	1.5%	61	3.1%
Дундговь	5	0.3%	11	0.6%	19	1.0%	35	1.8%
Завхан	8	0.4%	21	1.1%	27	1.4%	56	2.9%
Орхон	9	0.5%	34	1.7%	35	1.8%	78	4.0%
Өвөрхангай	5	0.3%	50	2.6%	30	1.5%	85	4.4%
Өмнөговь	10	0.5%	21	1.1%	22	1.1%	53	2.7%
Сүхбаатар	5	0.3%	21	1.1%	20	1.0%	46	2.4%
Сэлэнгэ	10	0.5%	35	1.8%	36	1.8%	81	4.2%
Увс	8	0.4%	28	1.4%	25	1.3%	61	3.1%
Ховд	7	0.4%	28	1.4%	29	1.5%	64	3.3%
Хөвсгөл	11	0.6%	44	2.3%	50	2.6%	105	5.4%
Хэнтий	10	0.5%	25	1.3%	25	1.3%	60	3.1%
Нийт	319	16.4%	769	39.5%	859	44.1%	1947	100%

Хавсралт 2. Судалгаанд оролцогчдын ажил эрхлэлтийн байдал, насны бүлгээр

АЖИЛ ЭРХЛЭЛТИЙН БАЙДАЛ	Насны бүлэг							
	18-24		25-39		40+		Нийт	
	Count	%	Count	%	Count	%	Count	%
Хувийн хэвшлийн ажилтан	67	3.5%	295	15.2%	210	10.8%	572	29.5%
Төрийн албан хаагч	30	1.5%	239	12.3%	228	11.7%	497	25.6%
ОУБ-ын ажилтан	3	0.2%	9	0.5%	8	0.4%	20	1.0%
ТББ-ын ажилтан	2	0.1%	10	0.5%	16	0.8%	28	1.4%
Хувиараа бизнес эрхлэгч	7	0.4%	87	4.5%	132	6.8%	226	11.6%
Малчин	5	0.3%	16	0.8%	37	1.9%	58	3.0%
Тэтгэвэрт гарсан	1	0.1%	7	0.4%	150	7.7%	158	8.1%
Оюутан	152	7.8%	22	1.1%	1	0.1%	175	9.0%
Гэртээ, хүүхдээ харж буй	5	0.3%	28	1.4%	14	0.7%	47	2.4%
Ажилгүй, хайж байгаа	13	0.7%	22	1.1%	18	0.9%	53	2.7%

ИРГЭДИЙН САНХҮҮГИЙН МЭДЛЭГИЙН ТҮВШИН ТОГТООХ СУДАЛГАА 2022

Ажилгүй, хайгаагүй	5	0.3%	3	0.2%	20	1.0%	28	1.4%
Өвчтэй/ Disabled	1	0.1%	0	0.0%	9	0.5%	10	0.5%
Бусад	23	1.2%	18	0.9%	7	0.4%	48	2.5%
Мэдэхгүй	4	0.2%	8	0.4%	8	0.4%	20	1.0%
Нийт	318	0	764	0	858	0	1940	100.0%

Хавсралт 3. Судалгаанд оролцогчдын орлогын эх үүсвэр, насны бүлгээр

ОРЛОГЫН ЭХ ҮҮСВЭР	Насны бүлэг							
	18-24		25-39		40+		Нийт	
	Count	%	Count	%	Count	%	Count	%
Хувийн бизнес	37	1.9%	156	8.0%	196	10.1%	389	20.0%
Хувийн салбарт орон тооны бус ажилтан	40	2.1%	44	2.3%	31	1.6%	115	5.9%
Хувийн салбарт орон тооны ажилтан	53	2.7%	198	10.2%	163	8.4%	414	21.3%
Улсын байгууллагад ажилтан	23	1.2%	169	8.7%	159	8.2%	351	18.1%
Тэтгэвэр, тэтгэмж	4	0.2%	13	0.7%	142	7.3%	159	8.2%
Монголд амьдарч буй гэр бүл найз нөхдийн тусламж	86	4.4%	25	1.3%	21	1.1%	132	6.8%
Гадаадад амьдарч буй гэр бүл найз нөхдийн тусламж	7	0.4%	3	0.2%	9	0.5%	19	1.0%
Мал сүрэг, үр тариа борлуулсан орлого	7	0.4%	30	1.5%	44	2.3%	81	4.2%
Хадгаламжийн хүү, хөрөнгө оруулалтын болон бусад бүтээгдэхүүний орлого	7	0.4%	11	0.6%	10	0.5%	28	1.4%
Бусад	55	2.8%	117	6.0%	84	4.3%	256	13.2%
Нийт	319	16.4%	766	39.4%	859	44.2%	1944	100.0%

Хавсралт 4. Судалгаанд оролцогчдын тухай, насны бүлгээр

ОРЛОГЫН ТУХАЙД	В1. Хувийн орлого бий эсэх	18-24	25-39	40+
		В3. Сарын дундаж орлого	51.10%	70.10%
	420,000 хүртэлх	8.3%	5.6%	6.5%
	420,001-700,000	3.0%	8.2%	11.8%
	700,001-1,100,000	2.4%	11.2%	9.3%
	1,100,001-2,000,000	1.3%	6.9%	7.0%
	2,000,001-3,000,000	0.6%	3.6%	3.9%
	3,000,001-иас дээш	0.3%	1.6%	2.5%
	Тийм, үргэлж	23.2%	25.3%	28.9%

C2. Хоол хүнс болон бусад хэрэгцээтэй зүйлээ худалдаж авсаны дараа танд мөнгө илүү гардаг уу?	Тийм, хааяа	59.6%	54.7%	50.1%
	Үгүй	17.2%	20.0%	21.0%

Хавсралт 5. Санхүүгийн төлөвлөлт, насны бүлгээр

		18-24	25-39	40+	
САНХҮҮГИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	D1. Санхүүгээ (орлого, зарлага) төлөвлөдөг.	69.30%	69.40%	72.10%	
	D1B. Тийм бол, хэдий хугацаагаар төлөвлөдөг вэ?	Долоо хоног хүртэл	13.70%	10.90%	10.10%
		Долоо хоногоос 1 сар хүртэл	34.40%	23.90%	25.60%
		1 сараас 6 сар хүртэл	15.90%	19.50%	21.80%
		6 сараас 1 жил хүртэл	2.60%	7.30%	7.40%
		1 жилээс 2 жил хүртэл	1.90%	5.20%	4.30%
		2 жилээс 5 жил хүртэл	0.40%	1.30%	1.40%
		5 жилээс 10 жил хүртэл	0.00%	0.50%	0.20%
	10 жилээс дээш	0.00%	0.20%	0.50%	
	C5. Та өдөр тутамдаа худалдан авалт хийхдээ өөрийн хүсэл ба хэрэгцээг ялгаж чаддаг уу?	Тийм, үргэлж	35.60%	37.40%	38.60%
Тийм, хааяа		56.70%	51.30%	47.60%	
Үгүй		7.80%	11.40%	13.70%	

Хавсралт 6. Зээлийн тухайд, насны бүлгээр

		18-24	25-39	40+	
ЗЭЭЛИЙН ТУХАЙД	D2. Сард олох орлоготойгоо харьцуулахад та одоо хэдэн төгрөгийн зээлтэй вэ?	1 сарын орлогоос бага эсвэл адил	18.50%	22.40%	20.30%
		2-12 сарын орлоготой дүйцэхүйц	13.70%	25.40%	25.70%
		12 сарын орлогоос илүү хэмжээний	5.20%	31.10%	24.30%
		Ямар ч зээлгүй	62.60%	21.20%	29.70%
	C6. Сүүлийн 12 сарын туршид та 3 ба түүнээс дээш сарын хугацаагаар зээлийн эргэн төлөлт эсвэл өрхийн сар тутмын төлбөр тооцоогоо хоцроосон эсвэл төлж чадаагүй тохиолдол гарсан.	18.90%	29.90%	23.70%	

Хавсралт 7. Хадгаламж, эрсдэл даах чадвар, насны бүлгээр

		18-24	25-39	40+	
ХАДГАЛАХ ТУХАЙД,	D10A. Би ирээдүйдээ зориулж мөнгө хадгалахыг хичээдэг.	Тийм, маш их	42.20%	30.40%	25.40%
		Тийм, тодорхой хэмжээнд	47.80%	55.80%	50.30%
		Үгүй	10.00%	13.90%	24.30%

			18-24	25-39	40+
ЭРСДЭЛ ДААХ ЧАДВАР	D4. Том хэмжээний (хамгийн багадаа таны нэг сарын орлоготой тэнцэх) зарлагыг зээлгүйгээр нөхөх чадвартайдаа хэр санаа зовнидог вэ?	Санаа зовохгүй байна	18.50%	17.90%	20.20%
		Бага зэрэг санаа зовж байна	53.70%	48.20%	46.30%
		Их санаа зовж байна	27.80%	33.90%	33.50%
	D5. Та өндөр настай болж хөдөлмөр эрхлэхгүй үе ирэхэд зарлагаа нөхөх чадвартай байх талаар хэр санаа зовдог вэ?	Санаа зовохгүй байна	26.70%	19.90%	19.40%
		Бага зэрэг санаа зовж байна	48.90%	44.60%	43.20%
		Их санаа зовж байна	24.40%	35.60%	37.40%
	B6. Таны болон танай өрхийн санхүүгийн байдал жилийн дараа сайжирах болов уу, муудах болов уу эсвэл хэвэндээ байх болов уу?	Сайжирна	58.90%	52.60%	42.40%
		Муудна	12.60%	13.50%	18.30%
		Хэвэндээ байна	28.50%	33.90%	39.30%

Хавсралт 8. Судалгаанд оролцогчдын тухай нэмэлт мэдээллүүд, насны бүлгээр

			18-24	25-39	40+
НЭМЭЛТ АСУУЛТ	Н1. Санхүүгийн шийдвэрээс өмнө зөвлөгөө авдаг эсэх.	Бүрэн санал нэг	17.40%	11.90%	13.20%
		Ерөнхийдээ таарч байна	37.80%	34.40%	35.20%
		Бага зэрэг л	29.30%	35.40%	30.30%
		Огт үгүй	15.60%	18.40%	21.30%
	Н3. Мөнгө, санхүүгээ удирдах өөрийн чадвартаа итгэлтэй эсэх	Маш итгэлтэй	11.90%	16.80%	18.50%
		Итгэлтэй	50.00%	52.90%	53.20%
		Бага зэрэг итгэлтэй	38.10%	28.90%	27.50%
	Н4. Тодорхой хэмжээний хураамж төлж, их хэмжээний мөнгө олох боломж санал болговол та ямар арга хэмжээ авах вэ?	Саналыг шууд хүлээн авч, хөрөнгө оруулна	3.70%	2.30%	3.50%
		Мэргэжлийн хүнээс санхүүгийн зөвлөгөө авч шийдвэр гаргана	26.80%	19.70%	16.60%
		Найз нөхөд, гэр бүлийнхнээс зөвлөгөө авч, хөрөнгө оруулах шийдвэр гаргана	11.90%	16.70%	17.70%
		Тухайн баг, хүмүүсийг судлаж шийдвэр гаргана	10.80%	8.50%	6.00%

ИРГЭДИЙН САНХҮҮГИЙН МЭДЛЭГИЙН ТҮВШИН ТОГТООХ СУДАЛГАА 2022

Тухайн бизнес, эрсдлийг судлаж шийдвэр гаргана	20.80%	19.00%	20.10%
Хөрөнгө оруулахгүй	11.50%	11.90%	14.80%
Бусад	0.70%	1.50%	1.10%
Мэдэхгүй	13.80%	20.20%	20.20%

Хавсралт 9. Санхүүгийн боловсролын чадамж, насны бүлгээр

	18-24	25-39	40+
Санхүүгийн хандлага	2.1	2.2	2.2
Санхүүгийн мэдлэг	5.2	4.8	4.7
Эдийн засгийн мэдлэг	3.0	3.2	3.2
Санхүүгийн боловсролын чадамж	10.2	10.1	10.0

Хавсралт 10. Санхүүгийн боловсролын чадамж, хүйс ба байршлаар

	Санхүүгийн цогц мэдлэг		Санхүүгийн мэдлэг		Эдийн засгийн мэдлэг		Санхүүгийн хандлага	
	Эрэгтэй	Эмэгтэй	Эрэгтэй	Эмэгтэй	Эрэгтэй	Эмэгтэй	Эрэгтэй	Эмэгтэй
Улаанбаатар	2.1	2.1	5.2	5.1	3.1	3.1	10.4	10.3
Архангай	2.1	2.2	3.9	3.8	2.4	2.5	8.4	8.4
Баян-Өлгий	2.6	2.7	4.0	3.8	3.8	3.2	9.4	9.2
Баянхонгор	2.4	2.2	4.9	5.2	2.6	2.7	9.9	10.0
Булган	2.5	2.6	4.9	4.5	3.9	3.9	11.3	10.8
Говь-Алтай	2.1	2.1	4.3	4.3	2.2	2.4	8.7	8.8
Говьсүмбэр	1.5	2.3	6.0	4.3	3.0	2.9	10.5	9.5
Дархан-Уул	2.5	2.2	5.8	5.2	4.6	3.5	12.5	10.4
Дорноговь	2.4	2.2	4.9	5.4	2.9	3.1	10.2	10.7
Дорнод	2.2	2.3	4.8	5.3	2.8	3.2	9.1	10.3
Дундговь	2.6	1.9	4.0	5.1	2.5	2.5	9.1	9.5
Завхан	2.3	2.3	4.5	4.7	2.5	3.4	9.3	10.4
Орхон	1.8	2.0	4.1	3.5	2.7	2.7	8.7	8.2
Өвөрхангай	1.8	2.0	4.5	4.7	2.9	3.1	9.1	9.8
Өмнөговь	2.5	2.1	4.0	4.0	2.4	2.5	8.8	8.6
Сүхбаатар	2.3	2.5	5.6	4.3	3.7	3.3	11.4	9.7
Сэлэнгэ	2.2	2.3	5.4	4.7	2.9	3.2	10.4	10.1
Увс	2.5	2.6	4.7	4.8	3.3	3.2	10.3	10.1
Ховд	2.5	2.3	5.3	4.6	3.8	3.6	11.3	10.4
Хөвсгөл	2.1	2.1	5.4	5.3	4.0	4.0	11.5	11.4
Хэнтий	2.2	2.3	5.4	4.5	3.7	2.6	11.1	9.1
Улсын дундаж	2.2	2.3	4.8	4.6	3.1	3.1	10.1	9.8

Хавсралт 11. Санхүүгийн боловсролын чадамж, насны бүлэг ба байршлаар

	Санхүүгийн цогц мэдлэг			Санхүүгийн мэдлэг			Эдийн засгийн мэдлэг			Санхүүгийн хандлага		
	18-24	25-39	40+	18-24	25-39	40+	18-24	25-39	40+	18-24	25-39	40+
Улаанбаатар	2.0	2.1	2.1	5.5	5.2	4.8	3.2	3.3	3.0	10.8	10.6	10.0
Архангай	1.9	2.3	2.0	5.1	3.5	2.9	3.0	2.5	1.8	10.0	8.3	6.7
Баян-Өлгий	2.6	2.7	2.7	2.9	3.9	4.2	2.6	3.6	3.5	7.0	9.8	9.4
Баянхонгор	1.9	2.2	2.4	6.9	4.7	4.9	2.6	2.5	2.9	11.4	9.4	10.1
Булган	2.3	2.6	2.4	4.2	4.7	5.0	3.5	3.9	4.3	9.9	11.2	11.6
Говь-Алтай	1.4	2.2	2.2	3.6	4.6	4.2	1.2	2.5	2.6	6.2	9.3	8.9
Говьсүмбэр	2.8	2.1	2.0	5.5	5.0	3.6	2.5	3.8	2.0	10.8	10.9	7.6
Дархан-Уул	1.9	2.2	2.3	3.4	6.0	5.5	2.4	3.7	4.1	7.8	11.3	11.4
Дорноговь	1.9	2.3	2.2	5.4	5.4	4.9	2.2	3.3	2.9	9.5	11.0	10.0
Дорнод	2.0	2.2	2.4	4.8	4.9	5.2	2.6	3.0	3.2	9.0	9.0	10.6
Дундговь	1.3	2.3	2.1	5.2	5.7	4.2	2.0	2.5	2.6	8.5	10.5	8.9
Завхан	2.1	2.3	2.4	5.5	4.9	4.1	3.3	3.3	2.8	10.9	10.5	9.3
Орхон	1.6	2.0	1.9	4.8	3.8	3.4	3.6	2.5	2.6	9.9	8.3	7.9
Өвөрхангай	2.3	1.8	2.1	5.0	4.5	4.6	2.2	2.9	3.4	9.5	9.2	10.2
Өмнөговь	2.3	2.4	2.1	4.6	4.0	3.6	1.9	2.7	2.4	8.8	9.2	8.2
Сүхбаатар	2.4	2.4	2.5	4.6	5.2	4.3	3.3	3.9	3.1	9.6	10.9	9.8
Сэлэнгэ	2.0	2.1	2.4	6.0	4.1	5.4	2.5	2.8	3.4	10.5	9.1	11.2
Увс	3.0	2.6	2.4	4.5	5.0	4.6	3.6	2.9	3.6	10.6	10.3	10.0
Ховд	2.8	2.4	2.4	4.0	5.6	4.6	2.6	4.2	3.6	8.2	11.9	10.6
Хөвсгөл	2.0	2.3	2.0	4.7	5.0	5.8	2.7	3.5	4.7	9.5	10.7	12.6
Хэнтий	2.2	2.4	2.3	6.4	4.6	4.3	3.6	2.8	2.8	12.2	9.6	8.9
Улсын дундаж	2.1	2.3	2.3	4.9	4.8	4.5	2.7	3.1	3.1	9.5	10.0	9.7

Хавсралт 12. Санхүүгийн боловсролын чадамж, ажил эрхлэлтийн байдлаар

АЖИЛ ЭРХЛЭЛТИЙН БАЙДАЛ	Санхүүгийн хандлага	Санхүүгийн мэдлэг	Эдийн засгийн мэдлэг	Санхүүгийн боловсролын чадамж
Хувийн хэвшлийн ажилтан	2.3	5.2	3.4	10.7
Төрийн албан хаагч	2.3	4.9	3.4	10.3
ОУБ-ын ажилтан	2.3	4.6	3.5	10.3
ТББ-ын ажилтан	2.5	5.3	3.7	11.5
Хувиараа бизнес эрхлэгч	2.4	4.8	3.2	10.3
Малчин	2.1	4.2	2.4	8.7
Тэтгэвэрт гарсан	2.1	4.3	2.8	9.2
Оюутан	2.0	5.5	2.9	10.3

<i>Гэртээ, хүүхдээ харж буй</i>	1.9	4.2	2.4	8.5
<i>Ажилгүй, ажил хайж байгаа</i>	1.8	4.5	2.8	9.1
<i>Ажилгүй, ажил хайгаагүй</i>	2.1	4.3	2.8	9.1
<i>Өвчтэй/ Disabled</i>	1.6	3.1	1.6	6.3
<i>Бусад</i>	1.8	4.6	2.5	8.8
<i>Мэдэхгүй</i>	1.3	1.5	0.9	3.6
<i>Улсын дундаж</i>	2.0	4.3	2.7	9.1

Хавсралт 13. Санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээний хэрэглээ, ажил эрхлэлтийн байдлаар

Хэрэглээ ба ажил эрхлэлт	Хөрөнгө оруулалт	Банкны хадгаламж	Холимог хадгаламж	Хувийн хадгаламж	Даатгал	Сайн дурын даатгал	Ипотек зээл	Банкны зээл	ББСБ-ын зээл	Хувь хүмүүсээс авсан зээл	Ломбард болон өдрийн зээлийн үйлчилгээ	Данс шалгах, мөнгө шилжүүлэх	Цахим зээл	Крипто валют, цахим мөнгө
Хувийн хэвшлийн ажилтан	17.6%	51.7%	11.0%	22.5%	30.0%	31.8%	22.3%	41.9%	18.5%	27.6%	20.6%	65.1%	23.6%	21.3%
Төрийн албан хаагч	12.7%	48.7%	9.7%	20.7%	31.0%	28.8%	28.8%	47.1%	18.7%	27.0%	21.5%	62.2%	25.2%	14.3%
Олон улсын байгууллагын ажилтан	15.0%	65.0%	10.0%	20.0%	35.0%	35.0%	45.0%	30.0%	10.0%	35.0%	15.0%	55.0%	15.0%	15.0%
ТББ-ын ажилтан	6.9%	55.2%	6.9%	20.7%	51.7%	37.9%	17.2%	37.9%	6.9%	44.8%	10.3%	79.3%	20.7%	10.3%
Хувиараа бизнес эрхлэгч	21.1%	54.6%	11.9%	23.3%	28.2%	40.1%	23.3%	44.9%	22.9%	30.0%	26.9%	69.2%	17.2%	18.5%
Малчин	12.1%	43.1%	12.1%	24.1%	22.4%	29.3%	5.2%	31.0%	19.0%	25.9%	20.7%	48.3%	13.8%	12.1%
Тэтгэвэрт гарсан	15.2%	46.8%	11.4%	25.3%	19.0%	26.6%	13.3%	33.5%	11.4%	19.0%	18.4%	51.3%	11.4%	12.0%
Оюутан	12.0%	40.6%	10.9%	29.7%	20.0%	13.7%	11.4%	12.0%	12.6%	39.4%	23.4%	59.4%	21.1%	27.4%
Гэртээ, хүүхдээ харж буй	12.8%	57.4%	10.6%	27.7%	17.0%	19.1%	14.9%	34.0%	12.8%	23.4%	19.1%	61.7%	29.8%	14.9%
Ажилгүй, ажил хайж байгаа	11.3%	43.4%	1.9%	22.6%	17.0%	3.8%	7.5%	18.9%	9.4%	26.4%	20.8%	67.9%	20.8%	9.4%
Ажилгүй, ажил хайгаагүй	17.9%	53.6%	7.1%	32.1%	25.0%	25.0%	25.0%	7.1%	3.6%	39.3%	42.9%	67.9%	0.0%	14.3%
Өвчтэй/Хөдөлмөрийн чадваргүй	10.0%	10.0%	0.0%	30.0%	20.0%	20.0%	0.0%	20.0%	10.0%	30.0%	30.0%	60.0%	10.0%	10.0%
Бусад	10.4%	39.6%	8.3%	29.2%	22.9%	14.6%	18.8%	25.0%	12.5%	22.9%	14.6%	47.9%	18.8%	14.6%
Мэдэхгүй	10.0%	25.0%	15.0%	35.0%	5.0%	20.0%	10.0%	15.0%	20.0%	30.0%	20.0%	40.0%	25.0%	30.0%
<i>Average</i>	13.2%	45.3%	9.1%	25.9%	24.6%	24.7%	17.3%	28.5%	13.4%	30.0%	21.7%	59.7%	18.0%	16.0%

ИРГЭДИЙН САНХҮҮГИЙН МЭДЛЭГИЙН ТҮВШИН ТОГТООХ СУДАЛГАА 2022

Хавсралт 14. Санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээний хэрэглээ, байршлаар

Хэрэглээ ба байршил	Хөрөнгө оруулалт	Банкны хадгаламж	Холимог хадгаламж	Хувийн хадгаламж	Даатгал	Сайн дурын даатгал	Ипотек зээл	Банкны зээл	ББСБ-ын зээл	Хувь хүмүүсээс авсан зээл	Ломбард болон өдрийн зээлийн үйлчилгээ	Данс шалгах, мөнгө шилжүүлэх	Цахим зээл	Крипто валют, цахим мөнгө
Улаанбаатар	17.4%	59.7%	6.6%	28.0%	29.0%	29.6%	19.0%	31.3%	11.3%	31.3%	20.1%	72.1%	16.9%	19.4%
Архангай	8.6%	25.7%	8.6%	21.4%	25.7%	21.4%	18.6%	18.6%	22.9%	37.1%	22.9%	38.6%	28.6%	17.1%
Баянхонгор	9.2%	19.7%	9.2%	6.6%	15.8%	15.8%	17.1%	28.9%	17.1%	11.8%	9.2%	32.9%	13.2%	13.2%
Булган	10.8%	33.8%	4.6%	16.9%	33.8%	47.7%	30.8%	56.9%	20.0%	38.5%	23.1%	78.5%	16.9%	7.7%
Говь-Алтай	4.1%	16.3%	6.1%	4.1%	10.2%	10.2%	2.0%	10.2%	14.3%	2.0%	6.1%	16.3%	12.2%	6.1%
Говьсүмбэр	6.8%	29.5%	0.0%	9.1%	13.6%	15.9%	38.6%	43.2%	11.4%	34.1%	9.1%	45.5%	13.6%	4.5%
Дорноговь	15.4%	38.5%	15.4%	30.8%	15.4%	15.4%	23.1%	53.8%	15.4%	23.1%	7.7%	53.8%	7.7%	7.7%
Дундговь	26.9%	45.2%	15.1%	18.3%	6.5%	30.1%	22.6%	39.8%	20.4%	24.7%	23.7%	58.1%	17.2%	18.3%
Завхан	21.2%	55.8%	3.8%	9.6%	30.8%	42.3%	25.0%	57.7%	36.5%	21.2%	9.6%	65.4%	34.6%	11.5%
Орхон	14.8%	36.1%	4.9%	19.7%	19.7%	27.9%	19.7%	37.7%	16.4%	24.6%	11.5%	49.2%	24.6%	11.5%
Өвөрхангай	2.9%	20.0%	0.0%	0.0%	20.0%	17.1%	17.1%	34.3%	8.6%	20.0%	5.7%	51.4%	17.1%	5.7%
Өмнөговь	7.1%	53.6%	1.8%	12.5%	12.5%	8.9%	7.1%	30.4%	7.1%	14.3%	8.9%	91.1%	8.9%	7.1%
Сэлэнгэ	29.5%	50.0%	52.6%	50.0%	39.7%	41.0%	33.3%	41.0%	41.0%	46.2%	46.2%	56.4%	52.6%	56.4%
Хөвсгөл	14.1%	52.9%	16.5%	28.2%	57.6%	30.6%	20.0%	43.5%	32.9%	21.2%	35.3%	56.5%	12.9%	15.3%
Хэнтий	5.7%	45.3%	7.5%	15.1%	17.0%	24.5%	9.4%	37.7%	13.2%	34.0%	28.3%	43.4%	20.8%	13.2%
Average	10.9%	43.5%	6.5%	15.2%	21.7%	21.7%	34.8%	52.2%	13.0%	17.4%	8.7%	58.7%	10.9%	8.7%

